



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/527

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.28 Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19².3.6 дахь заалт, Зам, тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 90 дүгээр тушаал “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд үзлэг шалгалт хийж, авто үйлчилгээний ангилал тогтоох, холбогдох хууль тогтоомж стандартад нийцэж буй талаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн явуулах үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлын хэсгийн ахлагч Аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101116

Аймгийн Засаг даргын 2021 оны 10
дугаар сарын 26-ны өдрийн 11527
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

**АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД
ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д.Амартүвшин (Аймгийн Автотээврийн төвийн
дарга)

Гишүүд: Г.Баясгалан (Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин,
аялал жуулчлалын газрын дарга)

Д.Одонбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)

Б.Мөнхбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан
ахлах мэргэжилтэн)

Д.Батзул (Аймгийн Цагдаагийн газрын Экологийн ахлах мөрдөгч)

Б.Цэндсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч)

М.Мөнхбаатар (Аймгийн Автотээврийн төвийн үзлэгийн инженер)

Аймгийн Засаг даргын 2021 оны 10
дугаар сарын 26-ны өдрийн 715/21
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД
ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ**

Зорилго:

Арвайхээр суманд авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, стандартад нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг болгох, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг авто үйлчилгээний нэгдсэн санд оруулж, стандартад нийцсэн баталгаат үйлчилгээ иргэдэд үзүүлдэг болгох.

Хийгдэх ажил:

Ангилал тогтоож болохуйц иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгаа, хүний нөөцийн судалгаа, аюултай хог хаягдлын судалгааг нэгтгэн гаргах.

Хамтарсан хяналт шалгалтыг эрчимжүүлэн хийх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад авто үйлчилгээний байгууллагын ангилал тогтоох чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.

Галын дүгнэлт, байгаль орчины дүгнэлт гаргахад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.

Ангилал тогтоолгосон жишиг болохуйц авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, Autobox.mn авто үйлчилгээний нэгдсэн санг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд таниулах.

Хамрах хугацаа:

2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор.

Дүн гаргах:

2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор хяналт шалгалтын дүнг нэгтгэн авч, хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хүргүүлсэн байна.